



ХЭНТИЙ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 07 сарын 25 өдөр

Дугаар Б/39

Чингис хот

Э.Бат-Арсланг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, 33.4, Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3, 24.4, 17 дугаар зүйлийн 17.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 332 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт, 1999 оны 38 дугаар тогтоол, 2000 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Зэвсэгт хүчин, хилийн цэргийн офицер, ахлагч нарт төрийн тусгай алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам", 2004 оны 123 дугаар тогтоолоор батлагдсан "Зэвсэгт хүчний офицер, ахлагч, гэрээт цэргийн албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгох журам", Батлан хамгаалах яамны төрийн нарийн бичгийн даргын 2017 оны Б/102 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Цэргийн штабын Орон нутгийн хамгаалалт, сургалтын офицeroор ахмад Э.Бат-Арсланг 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс томилсугай.

2. Э.Бат-Арслангийн цалинг ТТ-13-4 шатлалаар, цолны цалингийн хувийг 30, удаан жилийн нэмэгдлийг 12, онцгой нөхцөлийн нэмэгдлийг 10 хувиар тооцож олгохыг нягтлан бодогч /Н.Шинэбаяр/-д зөвшөөрсүгэй.

3. Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга бөгөөд эрх бүхий албан тушаалтан Ж.Гантулгад 30 хоногийн дотор гаргаж өгөхийг даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР